

## ТҮҮХ, СОЁЛ

### ХЯТАДАД АРДЫН ЭМНЭЛЭГ ҮҮСЧ ХӨГЖСӨН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Г. Гунгаа\*

Хятадын ардын эмнэлэг бол үүсэл хөгжлийнхөө хувьд өлөөртний түүхтэй юм.

Бөө мөргөлийн домнох аргын үндсэн дээр хятад эмнэлгийн анхны эх суурь тавигдсан гэж үздэг. Анх МЭӨ 77 оны үед Лю Шян (баруун хан улсын зохиолч, бичиг зүйч)-ы туурвисан «Сургаал билэг» гэдэг бичигт эрт дээр үед Мяо фү гэдэг хүн байсан ба энэ хүн бол Мяо омгийн бөө байсан бөгөөд «арван үсэгт тарни»-ийг хойт зүгт даатгаад хүнд хөнгөн өвчнийг домнох (заслын) аргаар засдаг байсан тухай тэмдэглэсэн байна.

Бөөгийн заслын гол нь домнох аргаар гай түйтгэрийг арилгахыг даатгах арга байсан боловч яваандаа архи болон ургамлаар хийсэн эмийг хэрэглэж байсан баримт бий.

«Уул усны судрын алс баруун орны бичиг»-т «Лин шань (одоогийн Вьетнамын төв хэсэгт буй) гэдэг газар байх ба Ү шань (мэрэг төлгийг үндэслэгч, зурхайч), Ү нь нь нарын арван бөө Лин шань газар ирж олон эм (ургамал) түүж авсан гэх ба бараг тэд нар эмийн ургамлыг анх хэрэглэж эхэлсэн байж ч болох ба Шань улсын үед дээрхи хоёр хүний нэрийн Шань нь гэдэг хоёр уг нь бөө гэсэн нэр үг болж хэрэглэгдэж байсан тухай дурьдсан байхаас гадна, Зүүн Жоу улсын үед (МЭӨ 770—256) бөөгийн домнох арга, эмнэх арга хоёр салж, эмнэлэг нь тусгай эмээр өвчнийг эмнэдэг болсон тухай» тэмдэглэгдсэн байна.

Хятадын ардын эмнэлгийн түүхэнд бөө мөргөлийн домнож засах аргаас эмээр засах аргад аажмаар шилжинэ, домнох эмнэх ухсаан биеэ дааж салснаар Чин (МЭӨ 221—206), Хан (МЭӨ 206—220) улсын үед хятад эмнэлэг хөгжлийнхөө шинэ шатанд орсон гэж үздэг байна.

Зүүн хан (МЭ 25—220) улсын үед Жан Жун жин гэдэг нэгэн сайн эмч байжээ. Тэр үед халдварт тахал, хижиг өвчин их дэлгэрснээс үндэслэн Жан жун жин «Нэй жин», «Нань жин» гэдэг нэрт судруудыг судлахын зэрэгцээгээр ардын хэрэглэж ирсэн уламжлалт жорнуудыг цуглуулж нэгтгээд «Томуу өвчнийг тайлбарлах нь» гэдэг бичгийг туурвижээ. «Томуу өвчнийг тайлбарлах нь» гэдэг бичгийн дотор Хятадын ардын эмнэлгийн зүй, түүнийг эмчлэх зарчмын үндсийг тайлбарласнаараа хятад эмнэлгийн эмчлэн засах эх суурийг тавьж өгснөөр барахгүй, энэ ном дотор бичигдсэн 300—400 эмийн жорын ихэнхийг тэр хэвээр нь нийтээрээ хэрэглэсээр өшөө хүрч байна.

Энэ номонд арга билгийн онолыг тайлбарлаад дараа нь хөлс, шүлс, ялгадас, халах, хөрөх зэрэгт тулгуурлан эмчлэх аргыг бий болгосноороо Хан улсын үеийн эмнэлгийн баялаг туршлагаар Хятадын ардын эмнэлгийн хөгжилд чухал хувь

\* Г. Гунгаа. Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

нэмэр оруулсан хүн гэж үздэг тул хойч үеийнхнийхээ дотор «Огоч багш» гэж алдаршжээ.

Хан улсын Хуа туо (МЭӨ<sup>9</sup>—208) бол Хятадын ардын эмнэлгийн нэртэй эмчийн нэг юм. Хуа туо эмнэлгийн олон төрөлд нэвтэрхий мэргэжсэн хүн байсны дотор зүү төөгүүр ба мээ заслалыг илүү сонирхдог хүн байжээ. Мансууруулах болон мэдээ алдуулах эм бүтээгээд өвчтөнд мээ заслал хийхээс өмнө архиар хийсэн эмээр мэдээ алдуулаад бүх бие мэдээ алдсаны дараа мээ заслал хийдэг байжээ. Энэ нь өвчтөний зовнуурыг багасгах гол арга болж байжээ. Энэ аргыг нээснээрээ дэлхийд анх түрүүн өвчтөний бүх биеийг мэдээ алдуулах арга хэрэглэсэн хүний тоонд зүй ёсоор ордог байна.

Тэрээр өвчтөнд зориулсан дасгалыг бар, бута, баавгай, сармагчин, жигүүртэн зэрэг таван төрлийн амьтны хөдөлгөөнийг дууриан дүрсэлж зохиосон нь хүний биеийг хөдөлгөөнд оруулахад ихээхэн тохиромжтой дасгал болсон байв.

Лу улс (МЭӨ<sup>10</sup>—256)-ын дээд түшмэд Жи Канз гэдэг хүн Кунз (МЭӨ 551—479)-д нэгэн эм илгээсэнд «Би эмний хүчийг мэдэхгүй тул амсаж үл чадна» гэж хэлсэн байдаг. Байлдаанч улсуудын үеийн (МЭӨ 475—403) Тэн улсын Тэн Вэнь гүн гэдэг сударт Баруун хан улсын үеийн Шан шү гэдэг бичигт «хүн эмийг уухад өвчтөн хүний дотор эвгүй оргихгүй бол өвчин үл эдгэрнэ» гэсэн байх ба «эмч эм барих, өвчтөн эмийг хүртэх нь парийн учир холбогдолтой байдаг тул эзэн хүн эмийг хүртэхэд сайд нь эхлээд амсана, эцэг эх нь эмийг хүртэхэд хүү нь эхлээд амсах хэрэгтэй, энэ нь өвчтөн хүнд учрах аюулыг арилгана гэсэн утгатай байх ба Шүй Да гүн гэдэг хүнд хумхаа өвчин туссанд эм хүртэхдээ эхлээд том хүү Шүй жи-д амсуулаагүй тул Шүй да гүн эмэндээ хордоод нас барсан тул том хүү Шүй жи бүтэн жил уйлж байгаад нас баржээ» гэж тэмдэглэсэн байв. Үүнээс үзэхэд эм бий болсон нь дэвшилттэй боловч эм нь хүчтэйн дээр харьцангуй бүдүүлэг байсан учир хүнд эм болохын зэрэгцээгээр хордуулах муу нөлөөтэй байсан нь харагдаж байна. Гэвч эмээр өвчнийг засах нь зөв юм гэдгийг ойлгосны үндсэн дээр эм хийсэн нь ихээхэн амжилтанд хүрсэн нь мэдээжийн хэрэг юм.

Байлдаанч улсуудын эхэн үед (МЭӨ 455—395) Ли Ли гэдэг хүний тооцоолсноор «жирийн нэгэн тариачин өрхийн зардалд эмчилгээний зардал багтдаг байсан» гэсэн нь овгийн байгуулал устсаны дараа ардуудын дотор эмч байдаг байсан ба энэ үеэс эхлээд эмчлэх дадлага туршлага улам их хөгжинж ирсэн тухай дурьдсан байдаг.

«Түүхэн тэмдэглэл» (Хан ү дигийн үе МЭӨ 104—31 он эмхэтгэж зохиогдсон)-д «Байлдаанч улсуудын үеийн нэртэй эмчийн нэг Бянь чүэ бол судасны засал зүйг анх нээсэн хүн юм. Тэрээр хүний царай зүс, дууны өнгө, хөдөлгөөнөөр өвчний хүнд хөнгөнийг мэддэг байсан ба тэр үеийн улсууд (байлдаанч улсууд)-ын томоохон хотуудын хооронд тэнүүчлэн явж хүн ардыг эмчилж, эм барьдаг хүн байв.

Жао улсын нийслэл Хань дань хотод байхдаа эмэгтэйчүүдийг чухалчлан үздэг заншлын үндсэн дээр эмэгтэйчүүдийн эмнэлгийг бий болгоод, Жоу улсын нийслэл Луо ян хотод байхдаа настангуудыг хүндэтгэн үздэг заншлыг үндэслэн нүд, чихний эмнэлгийг бий болгож, Чинь улсын нийслэл Шянь ян хо-

тод байхдаа хүүхдийг хайрлаж хүндэтгэдэг заншлыг үндэслэн хүүхдийн эмнэлгийг бий болгожээ.

Гэтэл Чинь улсын эмч Ли ши гэдэг хүн мэдлэг мэргэжлээр түүнд хүрэхгүй гэдгээ мэдээд Бянь чүэ-г хорлож алсан» гэж тэмдэглэсэн байв.

«Түүхэн тэмдэглэл»-д нэртэй сайн эмч нарын нэрсийг дурьдахдаа Бянь чүэ-гийн нэрийг хамгийн эхэнд бичсэн байдаг нь учир холбогдол бүхий юм.

Бянь чүэ бол бөөгийн домын аргыг эсэргүүцдэг байсан ба «эмчилж үл болох зургаан төрлийн өвчин байгаа»-г дурьдаад «бөөд итгээд эмнэлэгт үл итгэх нь эмчилж үл болох өвчний нэг мөн» гэж хэлсэн нь бий.

Бянь чүэ-гийн туурвисан «Нань жин» (хятад эмнэлгийн тулгуур бичиг бүгд 81 боть)-д хүний хүүрийг задлан шинжлэх аргаар судалсны засал зүй ба өвчнийг тодорхойлох аргыг нээснээрээ анагаах ухааныг чөтгөр бурханд бишрэх ойлголтоос бүрмөсөн ангижруулсанаараа дэвшилттэй юм.

Бөө мөргөл ба эмнэлэг хоёрыг заагласнаараа хятадын ардын эмнэлгийн арга туршлагыг нэгтгэн дүгнэсэн анхны хүн бол Бянь чүэ мөн бөгөөд судас барих заслыг үндэслэгч юм.

Байлдаанч улсуудын үеийн «Нэй жин», «Сү вэнь», «Лин шү», «Жэнь жин» зэрэг хятад эмнэлгийн дээж бичгүүдэд хүүрийг задалж ажиглалт хийгээд өвчний учрыг тогтоох, зүү төөнүүрээр засах аргаар эмнэлгийг хөгжүүлэх аргыг тодорхойлсон олон баримт бий.

Гэвч тэр үед хүүрийг задлан шинжлэх арга нь харьцангуй бүдүүлэг байсан тул өвчний учир шалтгааныг тодорхойлохдоо арга билиг таван махбодын онолд тулгуурлахаас өөр аргагүй байжээ.

«Жоу улсын ёс заншил» хэмээх сударт «срдны эмнэлгийн ёсонд их эмч, дотрын эмч, мэс заслалын эмч, хоол хүнсний эмч, малын эмч гэж байсан» тухай дурьдсан нь бий.

«Хан улсын бичиг»-т эмнэлэг нь ерөнхийдөө эмнэлэг, эмнэлгийн онол гэсэн хоёр бүлэгт хуваагдах ба дотор нь эмийн жор, дотор, эмэгтэйчүүд, хүүхэд, хий мэдрэл гэсэн таван хэсэгт ангилна. Өвчнийг эмээр засах, хоолоор засах хоёр арга гол нь болно.

Үүнээс гадна өрх гэрийн дотор хурьцлыг зохицуулж урт наслах, иллэг хийх, хөдөлгөөнт дасгал хийж урт наслах, бурхан сахиусын аргууд бас байдаг» гэж дурьдсан байна.

Хятадын түүх шагирт бичсэнээс үзэхэд эмнэлэг, эм хоёр бий болсон тухай олон баримт байх ба бөө мөргөл, бөөгийн домнож засах арга хоёр нь хоорондоо салшгүй холбоотой нэгэн үед үүссэн байдгийн нэгэн адил эмнэлэг, эм хоёр салшгүй холбоотой нэгэн үед үүссэн нь тодорхой юм.

Үүнээс гадна хятад дахь эмийн бус эмчилгээний үүсэл хөгжил мөн л өнө эртний түүхтэй юм.

Бурхны сургаалыг танин мэдэхүйн хий тамирын дасгал бол зөвхөн хятад улсад л дорвитой хөгжиж байгаа бөгөөд энэ нь орчин үед эмийн бус эмчилгээний олон төрөл зүйлүүдийн дотроос таван тивийн хүн ардын анхаарлыг татаж байгаа хамгийн их цэгцэрч бүрэлдсэн эмийн бус эмчилгээний иж бүрэн төрөл зүйлийн нэг болоод байна.

Хятад дахь хий тамирын дасгал нь түм буман жилийн тэртээгээс үүсч эхэлсэн хэдий боловч нийтэд дэлгэрээгүй, зөв-

хөн багшаас багшид дамжин уламжлагдаж, тухай тухайн үедээ зөвхөн нэг хүнд өвлүүлэн үлдээх байдлаар уламжлагдаж ирсэн түүхтэй юм.

Хятад улс дахь хий тамирын дасгалын орчин үеийн нэрт хүмүүсээс дурьдвал:

Номын багш Хай дэн (1905—1990), (Хо нань мужийн Шао Линь хийдийн хувраг байсан), Янь шинь (одоо Америкад цагаачлан суудаг), Жан Хун бао (си чуан мужийн), Тянь Гуи шэн (Хо нань мужийн) зэрэг хүмүүсийн нэр тодроод ид шидээ олоод байгаа юм.

Хий тамирын дасгал нь энэтхэгийн гүн ухааны нэгэн урсгал болох бие, сэтгэл, хэл гурвыг ариутгах «нууц тарьна»-ын ёс болон бурхны сургаалын «даяаны ёс»-нд үндэслэн буй болсон хий мэдрэлийг танин мэдэхүй буюу оюуны увидастай холбоотой ойлголт болох учраас хэн хүнгүй өвлөн авч, гүнд нь шууд орж танин мэдэж болдоггүй нууцлагдаагүй нууц болж хадгалагдсаар иржээ. Гэвч хий тамирын дасгал зүйг хүн төрөлхтний танин мэдэх хэмжээ улам нэмэгдсээр байна.

Орчин үед хий тамирын дасгал нь шинжлэх ухааны биеэ даасан нэгэн салбарын хэмжээнд судлагдаж байна.

Хий тамирын дасгал нь зөвхөн хүний биеийг эрүүлжүүлж өвчнийг засаад зогсохгүй, хүүхэд, залуучууд, хөгшид настангуудын биеийг чийрэгжүүлэхээс гадна, тамирчид болон цэрэг эрийн бэлтгэл сургуулийг төлөвшүүлэхэд эрхэм чухал ач холбогдолтой болох нь зөвхөн хятад улсын хэмжээнд төдийгүй олон улсын хэмжээнд батлагдаад байна.

Орос, Америк зэрэг улсууд анх Хятад улсаас хий тамирын дасгалыг зээлдэн авсан хэдий боловч одоогийн байдлаар хий тамирын дасгалыг танин мэдэх түвшин болон уг дасгалыг амьдралд хэрэгжүүлж байгаа байдлаараа Хятад улсын хий тамирын дасгалын дасгалжилтын түвшингээс нэг их дутахааргүй болоод байгааг тэмдэглэхэд илүүдэхгүй юм.

Манай орны хувьд хий тамирын дасгалын дасгалжилтын байдал зөвхөн эхлэлийн төдий байгаа нь харамсалтай хэдий ч нэгэнт эхэлсэн зүйлээ «ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал» гэдэгчилэн туйлд нь хүргэж чадвал нэг ч их оройтоогүй байна.

Өвчнийг засахад домнох засал, тарьнын засал, илэх засал, сэтгэлийн засал, хий тамирын засал, эмэн засал, мэсэн засал зэрэг олон төрөл зүйл байдаг байна.

Үүний дотроос хий тамирын засал нь бусад заслудаас илүү өгөгжтэй юм гэдгийг сайтар ойлгохын зэрэгцээгээр эм бэрх өвчнийг номхотгох цорын ганц өрөндөг юм гэдэг ойлголтоос ангижирч монголын уламжлалт ардын эмнэлгийн заслудыг сэргээхийн чацуу бусад улс орны уламжлалт заслудыг зээлдэн хэрэглэж сурвал хүн ардын эрүүл мэндэд тустайгаас гадна эдийн засгийн хувьд ашигтай гэдгийг мэргэн оюундаа тунгаан болгоохыг хичээнгүйлэн захимаар байна.